



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

## ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

**Дотоод аудитын нэр:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны үр дүн

**Тайлангийн код:** ХШҮДАГ-2026/ДА/11

### АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу улсын хөрөнгө оруулалтын 2026 оны төсөв болон Засгийн газрын нөөц сангаас санхүүжих эх үүсвэртэй 45 төсөл, арга хэмжээний 65 тендерийг зарлахаас 63 тендерийг зарлаж, 54 тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж төлөвлөгөөний биелэлт 83.1 хувьтай хэрэгжиж байгаа тул 2026 оны худалдан авах ажиллагааны үр дүн “Хангалттай” дүгнэгдэв.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтын хүрээнд ТЕЗ-ийн 2026 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтад батлагдсан 11 төсөл, арга хэмжээний 46,582.8 сая төгрөгийн төсөв буцаан татагдах магадлалтай байна.

Улаанбаатар хот  
2026 он

## АГУУЛГА

Нэр томьёо, товчилсон үгийн тайлбар.....	2
1. АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ .....	3
1.1 Аудитын зорилго .....	3
1.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт.....	3
1.3 Аудитын арга, аргачлал.....	3
2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....	4
Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөв.....	4
2.1 Худалдан авах ажиллагааны 2026 оны төлөвлөлт: .....	4
2.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, тендер сонгон шалгаруулалтын үр дүн: .....	5
3. ДОТООД АУДИТЫН ҮР ДҮН.....	7
Илэрсэн асуудал 1. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тендер шалгаруулалтын үнэлгээгээр шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг нийтлээгүй байна. ....	7
НЭГДСЭН ДҮГНЭЛТ.....	8
ЗӨВЛӨМЖ.....	8

## Нэр томьёо, товчилсон үгийн тайлбар

ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
СХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар
СХОГ	Санхүү, хөрөнгө оруулалтын газар

АУДИТЫН ХУГАЦАА

2026.01.01 – 2026.05.31

Хянасан: СХШУДАГ-ын дарга  
Аудитыг гүйцэтгэсэн: Ахлах шинжээч

Ч.Энх-Амгалан  
Ц.Алтанхуяг

## 1. АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

### 1.1 Аудитын зорилго

Сайдын төсвийн багцад батлагдсан салбарын 2026 оны хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дотоод аудит хийж, бодит нөхцөл байдлыг Төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулах, цаашид үр нөлөөг нэмэгдүүлэх санал дүгнэлт гарган, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ажиллав.

### 1.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын 2026 оны хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийн санхүүгийн анхан шатны баримт, үнэлгээний хорооны ажлын баримтад үндэслэн дотоод аудитыг гүйцэтгэв.

### 1.3 Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын /хуучин нэрээр/ 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж аудитыг гүйцэтгэсэн болно.

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил гүйцэтгэн ажиллав.

Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг хангалттай нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашиглалаа. Үүнд:

Төсвийн тухай хууль

Төрийн хяналт шалгалтын тухай хууль

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

Төрийн хэмнэлтийн тухай хууль

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”

Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”

## 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөв

Соёл, спорт, аялал жуулчлалын салбарт улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд 908,127.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 83 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг санхүүжүүлэх эх үүсвэрийг 199,661.3 сая төгрөгөөр баталсан.

Улсын төсөвт батлагдсан Салбарын хөрөнгө оруулалтын мэдээлэл

Хүснэгт 1 /сая төгрөгөөр/

Үзүүлэлт		Төсөл арга хэмжээний ангилал, тоо		Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
Аялал жуулчлал	барилга байгууламж	Шинээр	5	12,457.0	7,272.0
		Үргэлжлэх	2	2,166.3	852.1
Соёл	барилга байгууламж	Шинээр	6	39,727.7	17,534.2
		Үргэлжлэх	33	447,412.2	69,482.1
	Их засвар	багцтай	2	20,972.1	6,135.3
		багцгүй	3	9,789.0	3,678.0
	Тоног төхөөрөмж	Шинээр	3	187,909.5	45,541.5
		Үргэлжлэх	1	275.0	275.0
ТЭЗҮ	Шинээр	1	500.0	500.0	
Спорт	барилга байгууламж	Шинээр	5	35,215.6	11,586.9
		Үргэлжлэх	21	151,203.3	36,304.2
	ТЭЗҮ	Шинээр	1	500.0	500.0
дүн			83	908,127.7	199,661.3

Үүнээс 2026 онд шинээр эхлэх 307,070.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 төсөл, арга хэмжээнд 92,748.0 сая төгрөгийн санхүүжилтийг энэ онд олгох төсөв батлагдсан.

Мөн Засгийн газрын нөөц сангаас хөрөнгө батлагдсан Улсын драмын эрдмийн театрын дээврийн их засварын ажил эрх шилжиж ирсэн байна.

### 2.1 Худалдан авах ажиллагааны 2026 оны төлөвлөлт:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/428 дүгээр тушаалаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад батлагдсан 2026 онд шинээр эхлүүлэх төсөл арга хэмжээнээс гадна Барилгын хөгжлийн төв болон Үндэсний аудитын газрын хяналтаар баталгаажсан төсөвт өртгийн нэмэгдэлтэй үргэлжилж буй барилга байгууламжийн 2026 оны шинээр батлагдсан төсвийн дүнг тухайн барилга, байгууламжийн өмнөх гэрээний дүнтэй харьцуулан 15 хувиас дээш гарсан тохиолдолд гүйцэтгэгчийг хуульд нийцүүлэн сонгон шалгаруулах тендерийг зарлах шаардлага үүссэн байна.


Худалдан авах ажиллагааны 2026 оны төлөвлөлтөөр шинээр эхэлж байгаа болон үргэлжилж буй 44 төсөл арга хэмжээнээс 5 арга хэмжээ нь 25 багцтай, мөн Засгийн газрын нөөц сангаас эрх шилжсэн 1 төсөл арга хэмжээ нийт 65 төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар төлөвлөжээ

## Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн дүн мэдээ

Хүснэгт 2 /сая төгрөгөөр/

Үзүүлэлт		Төсөл арга хэмжээний ангилал, тоо		Багцын тоо	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
Аялал жуулчлал	барилга байгууламж	Шинээр	5	-	12,457.0	7,272.0
	барилга байгууламж	Шинээр	6	-	39,727.7	17,534.2
Соёл	барилга байгууламж	Үргэлжлэх	9	-	330,561.2	31,790.9
		Их засвар	багцтай	2	8	20,972.1
		багцгүй	3	-	9,789.0	3,678.0
	Тоног төхөөрөмж	багцтай	3	17	187,909.5	45,541.5
	ТЭЗҮ	Шинээр	1	-	500.0	500.0
Спорт	барилга байгууламж	Шинээр	5	-	35,215.6	11,586.9
		Үргэлжлэх	9	-	80,019.4	14,413.6
	ТЭЗҮ	Шинээр	1	-	500.0	500.0
Хэсгийн дүн			44	25	717,651.5	138,952.4
ЗГ-ын нөөц сан	Их засвар	УДЭТ	1		645.0	645.0
Нийт дүн			45	25	718,296.5	139,597.4

Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 187 дугаар тогтоол, 2026 оны 01 дүгээр 28-ны өдрийн 25 дугаар тогтоол, ССАЖЗ-ын Сайдын 2026 оны 17 удаагийн тушаалаар ТЕЗ-ийн төсөвт батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн байна.



### 2.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, тендер сонгон шалгаруулалтын үр дүн:

Улсын төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2026 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар 83.1 хувьтай хэрэгжиж байна.

Тайлант хугацаанд 65 төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаас 63 тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим системээр зарлаж, дараах 2 арга хэмжээг тодорхой шалтгаанаар зарлаагүй байна. Үүнд:

- Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Соёл, спорт, аялал жуулчлалын цогцолборын магадлалын ерөнхий дүгнэлтээр гарсан төсвийн дүн улсын төсөвт батлагдсан эх үүсвэрээр давсан – энэ онд санхүүжих дүн 3,211.8 сая төгрөг;
- Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Соёлын төвийн барилгын нэмэлт санхүүжилтийн төсөв алдаатай батлагдсан - энэ онд санхүүжих дүн 1.707.9 сая төгрөг.

**ТЕЗ-ын 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн мэдээ**

Үзүүлэлт		Төсөл арга хэмжээний ангилал, тоо		Багцын тоо	Төсөвт өртөг	Тендер төлөв						Гэрээ байгуулсан	
						Зарлаагүй	Зарласан	Шалгарсан	санал ирээгүй	Гомдол гарсан	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн
АЖ	барилга байгууламж	Шинээр	5	-	12,457.0	1	4	3		1	3,973.4	3	1,565.0
Соёл	барилга байгууламж	Шинээр	6	-	39,727.7	1	5	5			36,922.5	5	36,922.5
		Үргэлжлэх	9	-	330,561.2		9	9			122,586.1	9	122,586.1
	Их засвар	багцтай	2	8	20,972.1		8	7		1	20,332.6	7	12,304.0
		багцгүй	3	-	9,789.0		3	3			9,571.8	3	9,571.8
	Тоног төхөөрөмж	багцтай	3	17	187,909.5		17	12	3	2	177,865.4	12	9,894.1
	ТЭЗҮ	Шинээр	1	-	500.0		1			1	444.6		
Спорт	барилга байгууламж	Шинээр	5	-	35,215.6		5	5			31,652.5	5	31,652.5
		Үргэлжлэх	9	-	80,019.4		9	8		1	29,585.2	8	26,828.1
	ТЭЗҮ	Шинээр	1	-	500.0		1	1			440.0	1	440.0
дүн			44	25	717,651.5	2	62	53	3	6	433,374.1	53	251,764.1
ЗГ-ын нөөц сан	Их засвар	УДЭТ	1		645.0		1	1			580.4	1	580.4
			45	25	718,296.5	2	63	54	3	6	433,954.6	54	252,344.5

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан 63 удаагийн тендерийн үр дүнгээр 54 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг амжилттай сонгон шалгаруулж 252,344.5 сая төгрөгийн гэрээг байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны тендерийг цахим системээр зарлахад оролцогч санал ирүүлээгүй 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын тоног төхөөрөмж улсын хэмжээнд төсөл, арга хэмжээний багц -7 Хүүхдийн сэтгэл зүй, физиологи, бие бялдрын онцлогт нь нийцүүлэн спортын төрөлд сонгох тоног төхөөрөмж – 180.0 сая төгрөг;
- Байгалийн түүхийн музейн үзүүлэг дэглэлт, үзмэрийн интерьерийн зураг, цуглуулга, үзмэрийн тоноглол, тоног төхөөрөмж төсөл, арга хэмжээний
  - багц – 4 (Музейн зочин үйлчилгээ, нийтийн хоолны хэсгийн тоног төхөөрөмж) – 1,000.0 сая төгрөг;
  - багц – 5 (Музейн ашиглалтад шаардлагатай тээврийн хэрэгсэл) – 400.0 сая төгрөг.

Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын хийхэд гомдол гарч 2026 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар гүйцэтгэгчийг эцэслэн шийдвэрлээгүй 6 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- Өмнөговь аймгийн Булган суманд баригдах "Их говийн эко хүрээлэн" аялал жуулчлалын цогцолборын барилга – 2,495.0 сая төгрөг;
- Түүхэн, соёлын өвийн барилга байгууламжийн шинэчлэл, сэргээн засварлах их засварын ажлын багц 2 (Гандан дуган, Очирдарь зуугийн сүм, Номын сан, Дэдэн повран сэргээн засварлах ажил) - 4,525.1 сая төгрөг;
- Ховд аймгийн Мөст сумын Спорт заалны барилга – 2,865.1 сая төгрөг;
- Увс аймгийн Улаангом сумын Спорт цогцолбор барилгын зураг төсөв – 500.0 сая төгрөг;
- Байгалийн түүхийн музейн үзүүлэг дэглэлт, үзмэрийн интерьерийн зураг, цуглуулга, үзмэрийн тоноглол, тоног төхөөрөмж төсөл, арга хэмжээний
  - багц – 1 (Музейн үзүүлэг дэглэлт, үзмэрийн интерьерийн зураг, цуглуулга, үзмэрийн тоноглол, тоног төхөөрөмж дагалдах ажил, үйлчилгээ) – 169,748.3 сая төгрөг;
  - багц – 1 (Музейн үйл ажиллагааг дэмжих ажлын байрны тоноглол, тавилга, төхөөрөмж, тавилга) – 891.3 сая төгрөг;

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах, 13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох гэсэн заалтын хүрээнд ТЕЗ-ийн 2026 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтад батлагдсан 11 төсөл, арга хэмжээний 46,582.8 сая төгрөгийн төсөв буцаан татагдах магадлалтай байна.

### 3. ДОТООД АУДИТЫН ҮР ДҮН

<p><a href="#">Илэрсэн асуудал 1. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тендер шалгаруулалтын үнэлгээгээр шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг нийтлээгүй байна.</a></p>	
<p>Дотоод аудитын чиглэл: Худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулсан эсэх.</p>	
<p><b><u>Шалгуур үзүүлэлт:</u></b></p>	<p><b><u>Илэрсэн алдаа, дутагдал:</u></b></p>
<p>Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 4.1.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг захиалагчаас цахим системд нийтэлсэн төлөвлөгөө, тайлан, цахим системийн холбогдох бусад мэдээлэлд үндэслэн дараах шалгуур үзүүлэлтийн хүрээнд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ: 4.1.9.худалдан авах гэрээг цахим системд нийтэлсэн эсэх;</p>	<p>Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системд тендер зарлаж шалгаруулсан үнэлгээний үр дүнгээр гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээг нийтлээгүй байна.</p>
<p><b>Шалтгаан</b></p>	

Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажилласан албан хаагчид хууль тогтоомжийг мөрдөхгүй байгаа үйлдэл, эс үйлдэл
<b>Үр нөлөө</b>
Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.
<b>Дүгнэлт:</b>
Худалдан авах ажиллагааны үр дүнг нийтэд ил тод бүрэн мэдээлээгүй байна.
<b>Зөвлөмж:</b>
Тендер сонгон шалгаруулалтын үнэлгээгээр гүйцэтгэгчтэй байгуулсан бараа худалдан авах, ажил гүйцэтгэх гэрээг цахим системд нийтлэн, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангаж ажиллах;

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу улсын хөрөнгө оруулалтын 2026 оны төсөв болон Засгийн газрын нөөц сангаас санхүүжих эх үүсвэртэй 45 төсөл, арга хэмжээний 65 тендерийг зарлахаас 63 тендерийг зарлаж, 54 тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, төлөвлөгөөний биелэлт 83.1 хувьтай хэрэгжиж байгаа тул 2026 оны худалдан авах ажиллагааны үр дүнг “Хангалттай” гэж дүгнэв.

## ЗӨВЛӨМЖ

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нарт

Хугацаа

Зөвлөмж 1. Тендер сонгон шалгаруулалтын үнэлгээгээр гүйцэтгэгчтэй байгуулсан бараа худалдан авах, ажил гүйцэтгэх гэрээг цахим системд нийтлэн, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангаж ажиллах;

2026 оны 06-р сарын 25-ны дотор

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

---oOo---

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ 2026 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
МЭДЭЭЛЭЛ НЭГТГЭСЭН ХҮСНЭГТ**

МЯН, ТӨГ

Төсөл арга хэмжээний нэр	ХАА-ны арга	Төсөвт өртөг	Төндөр зарласан өгнөө	Оролцогчдын тоо	Шалгарсан компани	Гэрээ байгуулсан өгнөө	Гэрээний дүн	Дотоод аудит хийсэн эсэх	Илэрсэн зөрчил	Авсан арга хэмжээ
Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	НТШ	5,378,500.0	2026.04.13	1	Батс-Өргөө ХХК	2026.05.20 УТ2103400012	5,298,055.1	Тийм	Үгүй	-
Монголын Үндэсний археологи, палеонтологи, уссаатны музей, лаборатори /Төв, Зуунмод сум/	НТШ	3,096,310.0	2026.04.22	1	Тэрлүүн чансаа ХХК	2026.05.26 УТ2023400788 +4	3,096,308.9	Тийм	Үгүй	-
Залуучуудын сургалт, спорт хөгжлийн төв /Хэнтий, Бор-Өндөр сум/	НТШ	7,890,584.5	2026.04.13	1	Си Эйч Би Жи констракшн ХХК	2026.05.26 УТ2403100380 +1	7,884,326.7	Тийм	Үгүй	-
Спорт заалны барилга /Сэлэнгэ, Орхон сум, 1 дүгээр баг/	НТШ	687,000.0	2026.04.15	1	Эко буюнт ХХК	2026.05.18 УТ2403100368	686,994.0	Тийм	Үгүй	-
Усан Бассейн бүхий спорт цогцолборын барилга /Дундговь, Сайнцагаан сум/	НТШ	6,422,665.6	2026.04.20	1	Жи Жи Ай ХХК	2026.05.26 УТ2103100369	6,400,469.7	Тийм	Үгүй	-
Спорт цогцолборын барилга, 105 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум/	НТШ	412,900.0	2026.04.17	2	Викторибуйлди нт ХХК	2026.05.27 УТ210300108	412,850.0	Тийм	Үгүй	-
		23,887,960.1		7			23,779,004.4			